

ЭДИЙН ЗАСАГ

**ШИНЭЭР АЖ
ҮЙЛДВЭРЖСЭН АЗИЙН
ОРНУУДЫН ТУРШЛАГА,
СУРГАМЖ**

Ч. Сувд

Сүүлийн үед Ази, Номхон далайн бүс нутаг, тэр дундаас шинээр аж үйлдвэржсэн орнууд буюу «хоёр дөрвөл» дэлхийн улс орон, олон нийтийн анхаарлыг ихээр татах боллоо. Нэгдэх «дөрвөл» гэдэгт үйлдвэр, худалдааны эздийн гайхлыг төрүүлж байгаа Өмнөд Солонгос, Тайвань, Гонконг, Сингапур, хоёр дахь «дөрвөл» гэдэгт өмнөх дөрвийн араас яваа Малайз, Тайланд, Индонез, Филиппин хамрагдана. Эдгээрийн дотроос Сингапур, Малайз, Индонез, Тайланд, Филиппин нь Зүүн өмнөд Азийн орнуудын холбооны (АСЕАН) гишүүн улсууд юм.

Дэлхийн эдийн засагт хүчтэй нөлөөлж буй Япон, АНУ, нийтийн зах зээлийн орнуудын эдийн засаг эрчим хүч, нефть, валютын хямралд өртөж байсан 70-аад оны сүүлч 80-аад оны эхээр дээрх найман орны хөгжил түргэсэж, бүс нутагт төдийгүй дэлхийн тавцанд илт гарч ирэв. Шинээр үйлдвэржсэн азийн орнуудын эдийн засгийн зарим үзүүлэлтийг Азийн социалист орнуудынхтай харьцуулбал дараахь дүр зураг ажиглагдаж байна.

Хүснэгт № 1

**«Хоёр дөрвөл» ба азийн социалист орнуудын эдийн засгийн
хөгжлийн харьцуулсан үзүүлэлтүүд***

	Үндэсний нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт (%-иар)		Нэг хүнд ноогдох үндэсний нийт бүтээгдэхүүн (доллараар) 1988
	1981-1985	1986-1988	
Гонконг	4,2	9,8	7800
Өмнөд Солонгос	7,5	11,1	3800
Сингапур	6,0	6,9	8000
Тайвань	6,1	9,3	5600
Индонез	3,6	3,0	550
Малайз	5,1	4,0	2200
Филиппин	0,9	3,3	600
Тайланд	5,3	6,7	1400
БНХАУ	9,8	9,5	350
БНСВУ	7,1	4,0	150
БНМАУ	6,5	4,4	1400
БНАЛАУ	5,0	4,5	100
БНАСАУ			500
Дэлхийн дундаж			2300

Хүснэгтээс харахад шинээр аж үйлдвэржсэн орнуудын нэгдэх «дөрвөл»-ийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд Азийн социалист орнуудынхаас нэлээд дээгүүр, харин хоёр дахь «дөрвөл»-ийн хувьд

ойролцоо байна. Ялангуяа үндэсний нийт бүтээгдэхүүний жилийн дундаж хурдцаараа Индонез, Филиппин хоёр Азийн социалист орнуудаас доогуур, нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүнийхээ хэмжээгээр манай улсаас бусдаас нь дээгүүр байна.

Шинээр аж үйлдвэржсэн найман орны эхний «дөрвөл» нь нэг хүнд ноогдох үндэсний нийт бүтээгдэхүүнээрээ дэлхийн дундажаас 1,7—3,5 дахин илүү гарчээ. Ийнхүү шинээр үйлдвэржсэн азийн орнуудаас эдийн засгийн хөгжлөөрөө дөрөв нь дэлхийн дундажаас дээгүүр, Малайз тэр хавилцаа байгаа нь үнэхээр үлэмжийн амжилт юм. Гэхдээ эдгээр орнууд нь дэлхийн баячуул гэгдэх орнуудтай харьцуулахад тэднээс ихээхэн доогуур байгаа нь нууц бишээ. Тухайлбал, дэлхийн банкны илтгэлээс үзэхэд Бермундын арлын орнуудын хүн амд ноогдох бодит орлого 20,4; Швейцарынх 17,9; АНУ-ынх 17,5; Брунейгийнх 15,4; Японых 12,5; ХБНГУ-ынх 10,7; Английнх 8,9 мянган доллар болж байна.¹ Тэгэхлээр шинээр аж үйлдвэржсэн орнуудын тэргүүнд яваа Сингапур нэг хүнд ноогдох үндэсний нийт бүтээгдэхүүнийхээ хэмжээгээр дэлхийн хамгийн баян гэгдэж буй Бермундын арлынхаас 2,5 дахин, харин дэлхийн баячуулын сүүл барьж яваа Англиас 1900 доллараар доогуур байна. Хэргийн нарийн учир бол шинээр аж үйлдвэржсэн орнуудын эдийн засгийн хөгжил нь зөвхөн тоо үзүүлэлтээр хязгаарлагдаж байгаа биш, харин эдгээр орон дэлхийн хөгжилтэй орнуудыг «гүйцэж түрүүлэх» чиглэлээр үлэмжхэн амжилтад хүрч, өндөр хөгжилтэй капиталист орнууд, шинээр аж үйлдвэржсэн орнуудын хөгжлийн төвшингийн ялгааг багасгахад чиглэж байгаа явдал юм. Тэгвэл академич О. Богомоловын тодорхойлсноор «...бидний хувьд ярихад хичнээн гашуун ч гэлээ социалист орнууд хүн төрөлхтний нийт хөгжлөөс хоцорч, түүхэн үйл явцын хөвөө хязгаарт нь гарч байна»² Ийм нөхцөлд нийт хүн төрөлхтөн, түүний дотор шинээр аж үйлдвэржсэн орнуудын хөгжлийн ололт амжилт, бас бэрхшээлийг нь судлах явдал бидэнд онол-практикийн хувьд чухал ач холбогдолтой мэт санагдана. Саяхан хуралдсан МАХН-ын Төв Хорооны VII бүгд хурлаас «... социалист биш орнуудтай, ялангуяа Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай эдийн засгийн нээлттэй бодлого явуулах замаар харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх»³ зорилт дэвшүүлсэн билээ.

Энэхүү жижиг өгүүллийн хэмжээнд шинээр аж үйлдвэржсэн азийн орнуудыг бүхэлд нь ч тус тусад нь ч авч үзэх боломжгүй учир тэдгээр орны эдийн засгийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүдийг багтаасан хүснэгтийг уншигч танд сонирхуулья.

Хүснэгт № 2

Шинээр үйлдвэржсэн орнуудын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд (1986—1987 он)

	Өмн өд Соло нгос	Тайва нь	Гонк онг	Малай з	Синг апур	Тай лан д
1. Үндэсний нийт бүтээгдэхүүн (тэр бум доллар)	98,1	71,3	25,6	27,6	17,3	41,4
2. Үндэсний нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь: экспорт (%)	35,4	55,8	137,8*	50,4	130,1*	21,3
импорт (%).	31,7	33,9	138,1**	38,8	147,4*	22,2
Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн (%)	34,0	42,7	21,9	20,9	17,7	20,6
3. Экспорт (тэр бум доллар)	37,7	39,8	35,5	13,9	22,5	8,8
Капиталист орнуудын нийт экспортод эвлэх хувь (%)	1,8	2,1	1,9	0,7	1,2	0,5

4. Боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн (тэр бум доллар)	31,9	36,2	32,4	5,8	13,3	3,8
5. Түүний экспортод эзлэх хувь	91,9	90,9	91,3	41,7	59,1	43,2
6. Төлбөрийн балансын үлдэгдэл (тэр бум доллар)	+9,9	+18,2	+2,7	+2,3	+0,5	-0,6
7. Гадаад өр (тэр бум долл)		3,4	5,0	22,9	2,5	18,9
8. Алтан валютын нөөц (тэр бум доллар)	9,6	76,0	5,4	8,8	13,6	5,1
9. 500-аас дээш сая долларын гүйлгээтэй компаниудын тоо	23	7	8	5	4	4
10. Гадаадын шууд хөрөнгө оруулалт (тэр бум долл.)	1,0	0,4	11,5	0,5	1,5	0,2
11. Хөгжиж буй орнуудын дотор эдийн засгийн өрсөлдөх чадвараараа эзлэх байр	4	3	1	5	2	6

*дамжих экспорт, импорт ороод

Саяхан болтол тусгаар тогтнолоо олоогүй, эдийн засгийн хувьд бусдын хараат, хагас колонийн байдалтай байсан эдгээр орнууд хөгжлийн харьцангуй ахар богино хугацаанд сэргэн мандаж, дэлхийн аж ахуйн системийн дотор байр сууриа баттай эзлэхэд чухам ямар шийдвэрлэх хүчин зүйл байсныг тодруулах гэж судлаачид оролдож янз бүрийн тайлбар өгч байна. Тухайлбал, өмнөд солонгосчууд өөрийн амжилтыг тайлбарлахдаа хүн ардынхаа оюун ухаан, бие бялдрын чадвар, хичээнгүй идэвх зүтгэлийг тэргүүн зэрэгт тавьж, цаашилбал хөдөлмөр хэмнэлт, зорьсондоо хүрэхийн төлөө тун махруу шургуу зүтгэдэг үндэсний зан чанар юм гэж үзэж байна. Энэ мэтэд ямар нэгэн үнэний хувь байгаа нь эргэлзээгүй. Гэхдээ хэргийн учир бол улс үндэстний ямар нэгэн онцгой шинж чанар, байгаль, цаг уурын таарамжтай нөхцөл, оновчтой байршил төдийхөнд бус харин өөрийн орны хөгжлийн үзэл баримтлал, арга зам, давуу тал, нөөц бололцоогоо үнэн зөв тодорхойлж, тэдгээрийгээ амьдралд бодитой хэрэгжүүлж чаддаг байна.

Шинээр үйлдвэржсэн орнуудын «эдийн засгийн хөгжлийн гайхамшгийн» нэгэн гол түлхүүр, уг сурвалж, хөдөлгөгч хүч нь эдийн засгийг бүхэлд нь улсын мэдэлд авахад бус, харин гол төлөв хувьдаа өмчлөхийг хөхүүлэн дэмжсэн явдал юм. Ер нь эдийн засгийн командлах өндөрлөг, улс ардын аж ахуйн амин чухал салбар, объектуудыг хэдий чинээ улсын мэдэлд авч, төдийчинээ төрийн зүгээс нарийн чанд хяналт тавих тутам тэр улс орны эдийн засаг ихэд хөгжинө гэсэн үзэл баримтлал манай социалист орнуудын практик амьдралд гүнээ ноёрхсон нь үзтэл явц муутай болохыг харуулж байна. Өнгөц бодоход маргаангүй үнэн мэт энэхүү явуургүй үзэл бариимтлалаас хамгийн түрүүнд салж чадсанд л шинээр үйлдвэржсэн орнуудын үндсэн сургамж оршино.

Эдийн засгийг улсын ба хувийн өмчийн болгох бодлогын аль алиных нь талаар явцуу төсөөлөл, буруу ойлголт, хийсвэр дүр зураг бидэнд тогтсон байдаг бөгөөд түүнээсээ салж чадахгүй явсаар өдий хүрсэн гэвэл нэг их хэтрүүлэг болохгүй болов уу. Ялангуяа түүнийг хувьд шилжүүлэх бодлогыг гол төлөв өмч хөрөнгийг хуучин эзэд нь буцаан өгөх мэтээр, сайндаа хувь хүмүүст худалдах мэтээр ойлгож байсан цаг бий. Гэтэл шинээр үйлдвэржсэн азийн орнууд нь хувийн болгох явдлыг өргөн хүрээтэй ойлгож, өмч хөрөнгийг эзэмших утгаар нь бус, харин түүнийг үр ашигтай ашиглах, эцсийн ашигтай үр дагаварт хүрэх шижим түлхэцийг урьдал болгожээ. Энэ үндсэн дээр эдийн засгийг хувийн болгох бодлогын үзэл баримтлал үүссэн бөгөөд түүний тулгуур зарчмууд гэвэл: Засгийн газрын санхүүгийн элдэв хязгаарлал

тыг багасгах, улсын сектороос хувийн сектортой өрсөлдөх, үр ашгаа дээшлүүлэх боломжтой байх, улсын бус хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төрийн монопольчлол, хүнд суртлыг арилгах, капитал, үнэт цаас, валютыг оролцуулсан бүхэл бүтэн зах зээлийг бүрэлдүүлэх, засгийн газар, чөлөөт үйлдвэрлэгчдийн хоорондын гадаад үүргийн «хариуцлагыг» зааглах, улсын уламжлалт салбаруудад хүртэл чөлөөт үйлдвэрлэгчдийг татан оролцуулах зэрэг болно.

Практик дээр хувийн болгох үйл явц нь **нэгд**, засгийн газар үйлдвэр, аж ахуйн газраа байгуулчихсанахаа дараа хувьд өгч, үндсэн эрх мэдлийг өөртөө хадгалж үлдэх. **хоёрт**, хувь нийлүүлэгчдэд боломжийн үйлдвэрүүдийг түрээслүүлж, зөвхөн стратегийн ач холбогдолтой салбарт улс хяналтаа тогтоох, **гуравт**, үйлдвэрийг хэд хэдэн хувь нийлүүлэгчдэд худалдах, **дөрөвт**, улсын ба хувийн секторын хөдөлмөрийн хуваарийг тогтоох, **тавд**, шууд бусаар хувийн болгох, өөрөөр хэлбэл гэрээ хэлцэл, санхүү зээл, татварын бодлогоор дамжуулах гэсэн чиглэлүүд давамгайлж байна.

Хувийн болгох үйл явц нь аж үйлдвэржсэн орнуудад янз бүрийн хэлбэр, далайцтай байгаа бөгөөд тэр нь юуны өмнө тухайн орны зах зээлийн хөгжлөөс хамаарч байна. Тухайлбал, Гонконгийн эдийн засгийн амьдралыг зах зээлийн өрсөлдөөн үндсэндээ тодорхойлж байхад Малайзын эдийн засагт биет бүтээгдэхүүн, түүний солилцоо их рольтой байх жишээтэй. Нөгөөтэйгүүр хувийн болгох үйл явцад төрийн зүгээс шахалт хавчилт тулгарах явдал ч байна. Бас зарим салбарт улсын сектор давамгайлах, өөр хэсэгт хувийнх давамгайлах боломжтой байхад гурав дахь салбарт аль аль нь түншийн хувиар хамтран ажиллах боломжтой байдаг байна. Ийм учраас хувийн болгохыг хэдийд, хаана, ямар чиглэлээр нэвтрүүлэхийг нарийн бодолцож байж шийддэг туршлага аж үйлдвэржсэн азийн орнуудад нийтлэг юм.

Хувийн болгох практикаас үзэхэд аж үйлдвэржсэн орнуудад эдийн засгийн монопольчлол байна. Гэхдээ тэр нь эдийн засгийн амьдралд хувийнхийг үгүйсгэх. шахах, түрэн гаргахад бус, харин зэрэгцэн оршиж, нэг нь нөгөөдөө тус дэм үзүүлж аж ахуйн нэгдмэл, бүхэл бүтэн механизм бүрэлдүүлдэг тал илэрхий ажиглагдаж байна. Тухайлбал Сингапурт 450 компани нийгмийн нийт бүтээгдэхүүний дөрөвний нэгийг хянадаг. Нийгмийн нийт бүтээгдэхүүнийхээ 40 хувийг хуримтлалд оруулдаг атлаа улсын төсөв нь алдагдалгүй болдог байна. Үүний зэрэгцээ төрийн зүгээс хувийн сектор үйлдвэрлэлийн нөөцгүй, эсвэл яагаад ч ашиг хонжоотой ажиллаж чадахгүй болсон нөхцөлд шууд оролцож, саад хаалт тавьдаг, бусад тохиолдолд чөлөөтэй байлгадаг ажээ.

Аж үйлдвэржсэн азийн орнуудын туршлагаас үзэхэд эдийн засгийн утгаараа бол монополи өрсөлдөөний харьцааг зохицуулж, зах зээлийг бүрэлдүүлэхэд тусалдаг байна. Тэгснээрээ улс орны хөгжлийг саатуулдаггүй, харин ч дэвжин хөгжих бололцоо олгодог ажээ. Гэхдээ хувийн болгох үйл явц ямар ч саад бэрхшээлтэй тохиолддоггүй гэвэл эндүүрэл болно. Хувийн үйлдвэр нь хүмүүсийн сонирхол таашаал, зах зээлийн эрэлт хэрэгцээг түргэн мэдрэх чадвартай байдаг ч гэсэн эдийн засгийн сулавтар хөгжилтэй орнуудад түргэн зуур ашигтай ажиллаж, хуримтлалыг ихээр бий болгож чаддаггүй байна. Нөгөөтэйгүүр улсын үйлдвэрийн газраас хувийн секторт шилжсэн хүмүүс нийгмийн болон хууль зүйн хамгаалалтгүй, тэтгэлэг даатгалгүй үлдэх явдал ч гардаг байна. Тэр нь яваандаа «орон нутгийн» шинжтэй ажил хаялтыг нөхцөлдүүлж нийгмийг тогтворгүй байдалд хүргэдэг талтай.

Социалист орнуудад хувийн болгох нэр томъёог хэрэглэж заншаагүй байна. Гэлээ ч гэсэн эдийн засгийн энэ үзэгдэл Азийн социалист орнуудын заримд нь нэвтэрч, БНХАУ-д нэлээд ахиц олж, Вьетнам, Лаост үүсэх хандлагатай байна. Манай улсад хөдөө аж ахуйн гэрээ түрээсний зарим элементийг эс тооцвол хувийн болох явдал огт эхлээгүй гэхэд хилсдэхгүй. БНАСАУ-д байдал манайхтай төстэй юм.

Цаашдаа манай улс төлөвлөгөөт, зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэе, эдийн засгийн нээлттэй бодлого явуулъя, захиран тушаах системийн эдийн засгийн бүтцийг задлая гэвэл манайд хувийн болгох явцыг эхлээд зогсохгүй, түргэтгэх хэрэгтэй юм. Хувийн болгох үйл явцыг хөдөө аж ахуй хөгжүүлэх, үйлчилгээний хүрээг өргөтгөх, өргөн хэрэглээний зах зээлийн эрэлт, хэрэгцээг тогтворжуулах, алдагдалтай үйлдвэр, аж ахуйн газрыг багасгахад ашиглах явдал ирээдүйтэй бөгөөд үр ашигтай байх нь гарцаагүй.

* Asia-Pacific report. 1987—1988. p. 72—84.

¹ Цаг үе. , 1989, No 34

² О. Богомоллов. Социализм 90-ээд он. Залуучуудын үнэн. 1989 оны 10-р сарын 22., No 117

³ МАХН-ын Төв Хорооны VII бүгд хурал. УБ., 1989, 59 дэх тал

ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦГОЙ БҮС-ХАЙНАНЬ

Борлууд С. Жаргалсайхан

БНХАУ-д өөрчлөлт шинэчлэлтийг хэрэгжүүлж эхэлсэн цагаас хойш өмнөд хятадын тэнгист орших Хайнань арал хятадын удирдлага, эрдэмтэн, мэргэжилтнүүдийн анхаарлыг зүй ёсоор татах болсон юм. Юун хэмээвээс, энэхүү арал нь Тайвань, Гонконг, Макао болон зүүн өмнөд Азийн орнуудтай харилцахад ойр дөт, байгалийн ашигт малтмалаар арвин, байгаль, цаг уурын аятай таатай нөхцөлтэй болой. Иймд тус арлыг цаашид хөгжүүлэхэд бололцоотойгоос гадна энэ бүхэн нь хятадын улс төр, эдийн засгийн стратегид зүй ёсоор нийцэж байгаа юм.

Хайнань арлыг гадаадад нээх үйл явц гурван үе шаттайгаар хэрэгжиж байна.

1. 1981 оны 11-р сард Гуандун мужийн засаг захиргаа Хайнань аралд хөрөнгө оруулах, гадаадын худалдаачдад илүү уян хатан хандах шийдвэр гаргасан. Энэхүү арга хэмжээний үр дүнд 1981 онд тус арлын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 697 сая 400 мянган юань, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн 1 тэрбум 363 сая юань, гадаад худалдаа 45,7 сая доллар, бодитой ашигласан гадаадын хөрөнгө 1 сая доллар байсан бол 1983 онд дээрх үзүүлэлтүүд тус бүр 860 сая 200 мянган юань, 1 тэрбум 876 сая юань, 15 сая 700 мянган доллар, 4 сая 300 мянган доллар болсон байна.¹ Энэ хугацаанд арлын эдийн засаг